



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 495

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, 15,771,470.00 (арван таван сая долоон зуун далан нэгэн мянга дөрвөн зуун далан) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, устгах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

0002373

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн  
435 дугаар тогтоолын хавсралт



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтанд орсон огноо	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Програм (файл сервис AVG)	2016.05.04	1	482,790.00	482,790.00	482,790.00	-
2	Програм (palo alto)	2016.05.04	1	3,639,680.00	3,639,680.00	3,639,680.00	-
3	Програм (winsvrstd)	2016.05.04	4	2,260,940.00	9,043,760.00	9,043,760.00	-
4	Програм (symc)	2016.05.04	1	1,042,800.00	1,042,800.00	1,042,800.00	-
5	Програм (google earth)	2016.05.04	1	264,440.00	264,440.00	264,440.00	-
6	Програм (kaspersky)	2016.05.04	1	1,298,000.00	1,298,000.00	1,298,000.00	-
	Нийт дүн				15,771,470.00 (арван таван сая долоон зуун далан нэгэн мянга дөрвөн зуун далан)	15,771,470.00 (арван таван сая долоон зуун далан нэгэн мянга дөрвөн зуун далан)	-